



**“ӨСВӨР ҮЕ ХҮНС”
ОНӨААТҮГ**

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

“Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 154 тоот тогтоолоор нийслэлийн Баянзүрх, Хан-Уул дүүргүүдэд үйл ажиллагаагаа явуулж байсан “Балчирхан”, “Хан-Уул Хангамж” НӨҮГ-уудыг нэгтгэснээр үүсгэн байгуулагдсан. Бид одоогоор нийслэлийн Баянзүрх, Хан-Уул дүүргүүдийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд буюу 96 цэцэрлэг, 20 ерөнхий боловсролын сургуулийн нийт 185 хичээлийн байрны хүүхэд багачуудыг эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан, баталгаатай, чанартай хүнсний бараа бүтээгдэхүүнээр тасралтгүй хангах үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 93 дугаар тогтоолоор тус байгууллагын дүрэмд өөрчлөлт оруулснаар бие даан хоол үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлж байгаа ерөнхий боловсролын сургуулиудыг хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдээр ханган нийлүүлэх чиг үүрэг нэмэгдсэн.

Манай байгууллага нь одоогийн байдлаар 28 үндсэн ажилтан /батлагдсан орон тоо 28/, түр ажлын байранд 2 ажилтан нийт 30 албан хаагчтайгаар хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалтын 5 авто машин, бараа бүтээгдэхүүн хадгалах махны 1, хүнсний ногооны 1, хуурай хүнсний 8, нийт 11 агуулах /212.47 м²/-ын өрөө, тасалгааны хүчин чадалтайгаар үйл ажиллагаагаа явуулж, нийт 26 төрлийн 110 орчим нэрийн хүнсний бүтээгдэхүүнээр цэцэрлэг, сургуулиудыг ханган ажиллаж байна.



ЗОРИЛГО

Ханган нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг олшруулах, хүүхдийн насны онцлогт тохирсон илчлэг сайтай, шимт бодисын хэрэгцээ, витаминлаг байдлыг бүрэн хангасан хүнсээр хангах, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг цаашид дотоодын гарал, үүсэлтэй бүтээгдэхүүнээр бүрэн хангахад оршино.

ЗОРИЛТ

Байгууллагын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, зардлыг хэмнэх үүднээс цэцэрлэгийн нийтийн хоолны тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, мал аж ахуй, газар тариалан зэргээр туслах аж ахуй эрхэлж үйл ажиллагааны цар хүрээгээ тэлэх.



ХУУЛЬ, ДҮРЭМ

Манай байгууллага нь үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Хүнсний тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, НИТХТ-ийн тогтоолоор батлагдсан байгууллагын үндсэн дүрэм болон бусад хууль, эрх зүйн актууд, дээд шатны байгууллага, албан тушаалтнаас гаргасан тогтоол, захирамж, шийдвэрүүдийг мөрдлөг болгон ажилладаг.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДАВУУ ТАЛ

Зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн тогтвортой харьцаа, чанартай бүтээгдэхүүн нийлүүлдэг байнгын харилцагч түншүүд, санхүүгийн найдвартай эх үүсвэр.

ХЯНАЛТ, УЯЛДАА ХОЛБОО


Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгч гэрээт аж ахуй нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, бараа бүтээгдэхүүнийг тогтсон хугацаанд шинжилгээнд бүрэн хамруулан ажилладаг.

Манай байгууллагаас харилцагч цэцэрлэг, яслиудын тогооч, нярав, ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор сургалт, семинар зохион байгуулахын зэрэгцээ бараа бүтээгдэхүүний хүлээн авалт, агуулахын хүрэлцээ, бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалтад хяналт тавих үүднээс газар дээр нь зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн, харьяа дүүргийн мэргэжлийн хяналтын байгууллагатай байнгын харилцаатай хамтран ажилладаг.



БАТЛАВ.
“ӨСВӨР ҮЕ ХҮНС” ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Г.МӨНХЗҮЛ

ӨСВӨР ҮЕ ХҮНС ОНӨААТҮГ-ЫН УДИРДЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



“ӨСВӨР ҮЕ ХҮНС” ОНӨААТҮГ

2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрт нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан заалтуудын хэрэгжилт:

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль, “МУ-ын Засгийн газрын 2020-2024 оны Үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.3.10, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 27 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Тайлант оны байдлаар ХУД-ийн 60, БЗД-ийн 36, нийт 96 цэцэрлэг, тэдгээрийн салбаруудын хамт нийт 165 хичээлийн байр, мөн ерөнхий боловсролын 20 сургууль, нийтдээ 185 хичээлийн байрыг эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан 27 төрлийн 110 орчим нэрийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээр ажлын өдөр бүр түгээлтийн 5 машинаар тасралтгүй, шуурхай ханган нийлүүлж ажилласан. 8.7 тэрбум орчим төгрөгийн өртөг бүхий хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг цэцэрлэг сургуульд нийлүүлж, 2023 онд төлөвлөсөн борлуулалтын орлого одоогийн байдлаар 100 гаруй хувийн гүйцэтгэлтэй буюу орлого давж биелсэн байна. Ханган нийлүүлсэн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн бүрийг эрүүл ахуй, ариун цэврийн шинжилгээ баталгаажилтад зохих дүрэм, журамд заасан хугацаанд хамруулж ажилласан.

1.2.Нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, үр дүн:

1.2.1.Нийслэл, хотыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2.4.2-д: “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийг эрүүл баталгаат хоол, хүнсээр хангах нөхцөлийг бүрдүүлсэн байна”, Нийслэлийн Засаг даргын “2020-2024 оны Үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.3.5-д: “Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээнд хүнс ханган нийлүүлэх нэгдсэн тогтолцоог нэвтрүүлж, хүүхдийг эрүүл баталгаат хоол хүнсээр хангана”-гэсэн заалтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний түүхий эд нийлүүлэх үйл ажиллагааны тухай” А/657 дугаар захирамж гарч, эхний ээлжинд гал тогооны тоног төхөөрөмж, тогооч, бэлтгэгч зэрэг боловсон хүчний шаардлага хангасан нэр бүхий 10 сургуулиудад хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлж ажиллахыг манай байгууллагад даалгасан.Захирамж гарсны дараагаас одоогоор бие даан хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа Баянзүрх дүүргийн 14, 21, 88, 132, 137, 147, 148, 155, 156, 158, 165, Хан-Уул дүүргийн 26, 32, 60, 63, 75, 114, 130, 135, 156 гэсэн нийт 20 ерөнхий боловсролын сургуультай хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. Бусад

сургуулийн хувьд гал тогооны тоног төхөөрөмж, тогооч, бэлтгэгчийн орон тоо бэлтгэгдээгүй байна.

1.2.2.Нийслэлийн Засаг даргын “2020-2024 оны Үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.4.-заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу 98 төрлийн мэдээллээс өөрийн байгууллагын <http://childfood.ub.gov.mn/> цахим хуудсанд байршуулах шаардлагатай, хамаарал бүхий мэдээлэл бүрийг байршуулсан бөгөөд НЗДТГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу өөрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод хүргэсэн ажлын тайланг долоо хоног бүрийн Баасан гарагийн 10:00 цагаас өмнө НЗДТГ-т хүргүүлэн ажиллаж хэвшээд байна. Байгууллагын шилэн дансанд жилийн байдлаар 145 мэдээлэл оруулах ёстойгоос одоогоор 140 мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулаад байна. Харин 5 мэдээллийг он дууссаны даруу буюу 1-р сарын 15-ны өдрийн дотор оруулах ёстой болно.

1.3.Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн хэрэгжилт, үр дүн:

1.3.1.Нийслэлийн Засаг даргын “Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшин батлах тухай” 2023 оны А/688 дугаар захирамжийг хэрэгжүүлэх хүрээнд:

Нийслэлийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/688 дугаар захирамжаар эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшин батлагдсан.

2023 оны байгууллагын орлогын төлөвлөгөө 8,481,144.8 мянган төгрөгөөр, татварын дараах цэвэр ашиг 58.9 сая төгрөг байхаар батлагдсан. Жилийн эцсийн байдлаарх хүлээгдэж буй гүйцэтгэлээр 9.7 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой, ашиг төлөвлөсөн хэмжээнд ажилласан бөгөөд урд жилүүдийн мөн үетэй харьцуулан үзэхэд орлогын төлөвлөгөө хэвийн, давж биелэн ажилласан байна. Тайлант он дуусаж байгууллага ашигтай ажилласан тохиолдолд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас тогтоосон хэмжээгээр нийслэлийн төсөвт ногдол ашгийг бүрэн төлж барагдуулан ажиллана.

1.3.2.Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1592 дугаар “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2022 оны ажил дүгнэх тухай” захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр НЗДТГ-ын ажлын хэсгийн бүрэлдэхүүн ирж байгууллагын 2022 оны ажлыг дүгнэх шалгалт хийсэн. Улмаар ажлын хэсгээс 2023 оны үйл ажиллагаанд анхаарч ажиллах зөвлөмжийг албан бичгээр ирүүлсэн. Ирсэн зөвлөмжийн дагуу 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр 2023 онд зөвлөмжийг хэрэгжүүлэх 19 зүйл заалт бүхий төлөвлөгөөг байгууллагын захирал баталсан. Бид баталсан төлөвлөгөөний дагуу ажиллаж байгаа бөгөөд хэрэгжилтийн тайланг хагас жилийн байдлаар гарган 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлэн ажилласан. Жилийн эцсийн биелэлтийн мэдээг Үйл ажиллагааны тайлантай хамтатган хүргүүлж ажиллана.

1.3.3. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 06 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

2023 оны жилийн эцсийн байдлаар иргэд, харилцагчдаас манай байгууллага, үйл ажиллагаанд хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлт байхгүй байна. Харин байгууллагын дотоодоос буюу ажилтнуудаас удирдлагад хандаж гаргасан 16 өргөдөл байна. Эдгээрээс 15 нь аливаа төрлийн зээл авахтай холбогдуулан цалингийн буюу ажиллаж байгаа нь үнэн гэсэн утга бүхий тодорхойлолт гаргуулж авах, нэг нь жолооны С ангиллын сургалтад хамруулж өгөх тухай байсныг тус тус шуурхай шийдвэрлэж хариуг өгч ажилласан.

1.4. Нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байдал, үр дүн:

1.4.1. НЗДТГ-аас албан бичгээр үүрэг, чиглэл ирсний дагуу Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас авлигатай тэмцэх шүүр ажиллагааны хүрээнд тус байгууллагад ажиллаж байгаа нийт ажилтан, албан хаагчдын дунд дотоодын хяналт, шалгалтыг зохион байгууллаа. Дээрх дотоодын хяналт, шалгалтаар ажлын байрны тодорхойлолтод заасан мэргэжил, мэргэшил, ур чадварын шаардлагыг хангаагүй, хуулиар тогтоосон хязгаарлалтыг зөрчин томилогдсон, авлига, албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгүүлсэн, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, нийтлэг хэм хэмжээг удаа, дараа зөрчсөн ажилтан, албан хаагч тогтоогдоогүй болно.

1.4.2. НЗДТГ-аас албан бичгээр чиглэл ирсний дагуу Монгол Улсын ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд хэрэгжүүлэх “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон хот-Иргэний оролцоо” хаврын мод тарих аянд нэгдэж “Өсвөр үе хүнс” ОНӨААТҮГ-ын хамт олон Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр, Шинэ нисэхийн зам дагуу “Ногоон хэрэм” төслийн талбайд хуваарийн дагуу 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр өөрийн хуваарилагдсан талбайд нийт 25 улиас мод тарьсан. Мөн “Ногоон хот иргэний оролцоо” сэдэвт намрын мод тарих аянд нэгдэж чиглэл хуваарийн дагуу 2023 оны 10 дугаар сарын 07-ны өдөр дээрх талбайд 25 улиас мод тарилаа.



2023.05.12



1.4.3.Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны “Нийслэлийн нутаг дэвсгэрт бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах хуваарь батлах тухай” А/01 дугаар тушаалын дагуу сар шинийн баярыг угтсан “Хоггүй шинэлье”, “Хаврын их

цэвэрлэгээ 90 минут” уриан дор зохион байгуулагдсан 2 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээний ажилд ажилтан, албан хаагчид нар оролцож Дунд гол орчмын хуваарилсан талбайг цэвэрлэж, хогийг зохих газарт нь хүлээлгэн өглөө.



2023.04.14.

1.4.4. Улаанбаатар марафон-2023” найм дахь удаагийн олон улсын гүйлт 2023 оны 06 дугаар сарын 03-ны өдөр боллоо. “Өсвөр үе хүнс” ОНӨААТҮГ-аас эрүүл мэндийн гүйлтийн 5000 м-ийн зайд 5 ажилтан оролцсон.



2023.06.03



1.4.5. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх хүрээнд 2023 оны

06 дугаар сарын 08-ны өдөр болсон Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллаж, аюулгүй талбайд цугларах дадлага сургуулилт Баянзүрх дүүргийн 19-р хороонд байрлах “Газарчин” дээд сургуулийн гадна талбайд болж нийт ажилтан, албан хаагчид оролцлоо



2023.06.08

1.4.6. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн баталсан “Цасаа цэвэрлэе” аяны удирдамжид заасан нийтийн эзэмшлийн гудамж, явган хүний замын цас цэвэрлэгээний ажлыг батлагдсан хуваарийн дагуу тус байгууллагад хуваарилагдсан Доржийн гудамж Цайзын уулзвараас Хилийн цэргийн удирдах газрын уулзвар хүртэлх машин замын урд талын явган хүний замын цас, мөсийг “Өсвөр үе хүнс” ОНӨААТҮГ-ын нийт ажилтан, албан хаагчид 2023 оны 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 22-ны өдрүүдэд 2 удаа цас цэвэрлэлээ.

Явган хүний зам руу орц, гарц гаргасан автомашин засварын газрууд, “СУ” зэрэг хүнсний дэлгүүрүүдийг өөрийн эзэмшлийн талбайн цас, мөсийн арилгахыг сануулж ажилласан.





Их засаг их сургуулийн урд замын цэвэрлэгээ



1.4.7. Улаанбаатар хотын ерөнхий менежерийн тушаалаар “Эх дэлхийн цэвэрлэгээний өдөр” арга хэмжээнд манай байгууллага нэгдэж, 09 дүгээр сарын 16-ны өдөр батлагдсан хуваарийн дагуу Хуримын ордны урд уулзвараас Монголын Хүүхдийн ордны уулзвар хүртэлх зам талбайн хог, хаягдлыг цэвэрлэж оролцсон.



2023.09.16-ны өдөр. Эх дэлхийн цэвэрлэгээний өдөрт нэгдэв



ХОЁР.БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТ.

2.1. Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилт:

2.1.1.Байгууллагын үндсэн чиг үүргийн дагуу хүнсний түүхий эд, бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчээс хэрэглэгчид хүрэх дамжлагад хүнсний тэжээллэг чанарыг алдагдуулахгүй, илчлэг, амин дэмээр баялаг бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бүрдүүлж, нийслэлийн Баянзүрх, Хан-Уул дүүргийн сургууль болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад /84 цэцэрлэг, 20 сургууль, тэдгээрийн салбаруудын хамт нийт 185 хичээлийн байр/ хүнсний бүтээгдэхүүнийг зориулалтын 5 түгээлтийн авто машинаар ханган нийлүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа. Харилцагч цэцэрлэгүүдээс авсан захиалгын дагуу бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудаас 26 төрлийн 110 орчим нэрийн хүнсний түүхий эд, бараа бүтээгдэхүүнийг “Худалдааны агуулахын ерөнхий шаардлага MNS 5364:2011” стандартын шаардлагын дагуу тохижуулсан махны-1, хүнсний ногооны-1, цагаан идээний-1, хуурай хүнсний-8, нийт 11 агуулахын өрөө тасалгаанд хүлээн авч байна. Бүтээгдэхүүнүүдийг төрөлжүүлэн ангилж, ариун цэврийн шаардлага хангасан чийг, дулаан хэмжигч бүхий агуулахад хадгалж, эрүүл ахуйн шинжилгээнд тогтмол хамруулан ажиллаж байна. Тус байгууллага хүнс тээвэрлэлтийн дэглэм, нормыг хангасан хөргүүртэй бүхээг бүхий 5 тээврийн хэрэгсэлтэй бөгөөд тэдгээрт дулаан хэмжигч, термометр байрлуулснаар өдөр бүр хяналт тавин, бүртгэл хөтлөн ажилласан.

Монгол Улсын Их хурлын 2022 оны 17 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 218 дугаар тогтоол тус тус гарснаар цэцэрлэгийн насны хүүхдүүдийг цэцэрлэгт бүрэн хамруулах бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн өмчийн цэцэрлэг болон түрээсийн байрууд олноор ашиглалтад орохын зэрэгцээ гал тогооны тоног төхөөрөмжтэй болж бие даан хоол үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлэх болсон сургуулиуд манай газартай шинээр гэрээ байгуулснаар хүнсний бараа эргэлтийн хэмжээ огцом нэмэгдэж, ажлын ачаалал мөн нэмэгдсэн байна..

2023-2024 оны хичээлийн жилд 27 төрлийн 110 нэрийн /Эрүүл мэндийн сайдын баталсан тушаалын дагуу хуурай сүү, нөөшилсөн бүтээгдэхүүнүүд, масло, транс тостой бүтээгдэхүүний нийлүүлэлтийг зогсоосон/ орчим төрлийн хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийг ажлын өдөр бүр нийлүүлж ажиллалаа.

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох үйл ажиллагааг "Урагш нэг шат" бүртгэлийг хүлээж авч байгаа бүтээгдэхүүн тус бүрээр цахимаар үйлдэж архивлан хадгалдаг.

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох "Хойш нэг шат" бүртгэлийг 110 нэр, төрлийн хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдэд харилцагч цэцэрлэг, сургуулиудад бараа тус бүрээр өдөр тутам хүргүүлдэг. 2023 оны 01 дугаар сараас хойш өнөөдрийг хүртэл 8400 гаруй ул мөрийг мөрдөн тогтоох "Хойш нэг шат" бүртгэлийг хүргүүлж, гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилласан байна.

“Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль”-ийн 12.4. “Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага” MNS 6648:2016

стандартад заасан шаардлагыг хангахаар байгууллагын эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан хүнсний бүтээгдэхүүнийг сав баглаа боодол, шошгололтын байдалд хяналт тавьж, нийлүүлэгч гэрээт байгууллагаас ирж байгаа бүтээгдэхүүн тус бүрээр шалгаж агуулахад хүлээн авч хадгалан харилцагч цэцэрлэг сургуулиудад түгээж байна .

2.1.2. Тус байгууллагын дүрэм, дотоод журам, жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний нэг чухал ажил нь хүнсний бүтээгдэхүүнээр ханган ажиллаж байгаа цэцэрлэг, сургуулиудад “Зөвлөн туслах үйлчилгээ” байдаг. Цалин хөлсний хангалтгүй байдал, удирдлагын томилгоо зэргээс шалтгаалан сургууль, цэцэрлэгийн тогооч, бэлтгэгч, хүнсний нярвууд ойр, ойрхон солигддог төдийгүй, тэдгээрийг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр байнга хангаж, ур чадвар, хууль, эрх зүй мэдлэгийг дээшлүүлж байх шаардлага байдаг.

Тайлант хугацаанд 1 дүгээр сарын 18-ны өдөр Баянзүрх дүүргийн 8 дугаар цэцэрлэгт, 2 дугаар сарын 15-ны өдөр 149, 289 дүгээр цэцэрлэгт тус тус менежер, 2 эрүүл ахуйчийн бүрэлдэхүүнтэйгээр очиж зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн. Ноцтой зөрчил дутагдал илрээгүй.

2022-2023 хичээлийн жил дуусаж байгаатай холбогдуулан цэцэрлэгүүд хүнсний бүтээгдэхүүний үлдэгдэлгүй байх шаардлагатай байдаг. Иймээс 05 дугаар сарын 22-ноос 31-ний хооронд менежер, эрүүл ахуйн 2 ажилтан, түгээлтийн нярвуудын хамтаар эрсдэлтэй гэж үзсэн 17 цэцэрлэгээр очиж хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг зохицуулах, үлдэгдэлгүй ажиллах, захиалгаа тохируулах зэргээр дараах зөвлөн туслах үйлчилгээг өгч ажиллалаа.

Агуулахын стандарт MNS5364:2011 стандартын бандан тавиурыг шалнаас 50см хананаас 30см зайтай байршуулах, хүүхдийн тоог харгалзаж үзэж захиалгыг өгөхгүй бол хүнсний бүтээгдэхүүнийг ихээр захиалж эрсдэл үүсгэж байгаа талаар зөвлөгөө өгөв.

Хүнсний ногооны хадгалалт шууд халуун паарны хажууд хадгалагдаж байгаа нь ногооны чанарт шууд нөлөөлж байгаа тул хадгалалтын горимын талаарх зөвлөмж өгөв.

Мөн 10 дугаар сарын 25-ны өдөр “Харилцагч цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, хүнсний агуулахад зөвлөх үйлчилгээ”-ний ажлын удирдамжийг, ажлын хэсгийн бүрэлдэхүүний хамтаар байгууллагын захирал баталсан. Бүрэлдэхүүнд менежер Б.Зоригоо эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан Г.Энхбуд, Б.Болортуяа, хүний нөөц, ХАБ хариуцсан ажилтан Ш.Сэргэлэн нарын бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж 8-р сар буюу хичээлийн шинэ жил эхэлснээс хойш үйл ажиллагаагаа эхлүүлсэн 7 цэцэрлэг дээр очиж зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж ажилласан байна.

Илэрсэн зөрчил :

- Бүх агуулахуудад болон хөргөгч хөлдөөгчид термометр байршуулж бүртгэл хөтөлж хэвших
- Дээд газруудын тушаал шийдвэрийн хэргэжилтэд хяналт тавьж мөрдөх
- Агуулах стандартыг мөрдөж ажиллах
- Нийт ажилчид хөдөлмөр хамгаалалын хувцасыг бүрэн өмсөж хэвших
- Бэлэн болон түүхий эд бүтээгдэхүүнийг тус тусад нь хадгалах.
- Хоолны дээжийг зохих гр-ийн дагуу авч бүртгэл хөтөлж хэвших, термометр

байршуулж бүртгэл хөтөлж хэвших.

- Хүнсний бараа бүтээгдэхүүнийг зохих горимын дагуу хадгалах
- Хүүхдийн тоог харгалзан үзэж хүнсний захиалгыг өгөх
- Эхэлж ирсэн барааг эхэлж гаргах зарчмыг баримтлах
- Эрх зүйн баримт бичгийн бүрдлийн бөглөж хянах
- Агуулахад байгаа паарны халаалтыг зогсоох



Зөвлөн туслах баг цэцэрлэг дээр ажиллаж буй байдал




Зөвлөн туслах үйлчилгээгээр цэцэрлэг дээр ажиллав.

2.1.3. Дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу эрүүл, чанартай хүнсээр хангахаас гадна хэргэлэгчийг мэдээ, мэдээллээр хангах ажлын хүрээнд сургууль, цэцэрлэгүүдтэй хамтран “Эцэг эхийн өдөрлөг” буюу Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулдаг. Жишээлэхэд гэрээний дагуу хамтран ажилладаг нийслэлийн Баянзүрх дүүргийн 155 дугаар сургууль дээр зохион байгуулсан өдөрлөгөөр эцэг, эхчүүдэд хүүхдийн хүнсэнд хэрэглэж байгаа хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хэрхэн бэлтгэж, боловсруулдаг үе, шат дамжлага бүрээр нь тайлбарлан таниулах ажлыг хийсэн. Доор зургаар үзүүлэв.



Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ-ын эрүүл ахуйч Г.Энхбуд илтгэл тавьж буй байдал. 155-р сургууль





Хоолны загвар танилцуулга. 155-р сургууль

2.1.4. Дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу хүнсний ханган нийлүүлэлт хийхдээ зах зээлийн бөөний үнийг баримтлах бодлого барьдаг. Иймээс нийслэлдээ томд тооцогддог зах, худалдааны төвүүдэд тогтмол баг томилон ажиллуулж хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үнийн судалгааг хийж ажилласан.





Нярав Б.Баярмаа, Эрүүл ахуй Г.Энхбуд нар үнийн судалгаа хийж буй байдал.

2.2. Байгууллагын үндсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд гарсан төлөвлөлтийн баримт бичгүүд, түүний биелэлт үр дүн:

- Нийт 30 заалт буюу ажил, арга хэмжээ бүхий 2023 оны Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан баталж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, Нийслэлийн Засаг даргаар батлуулсан. Уг төлөвлөгөөний биелэлтийг эхний хагас жил, бүтэн жилээр тус тус гарган НЗДТГ-т журамд заасан хугацаанд нь хүргүүлсэн байна.
- Байгууллагын дотоод хяналт шалгалт зохион байгуулах 10 ажил, арга хэмжээ бүхий жилийн ажлын төлөвлөгөөг 01 дүгээр сарын 16-нд байгууллагын захирал батлан гаргаж, уг төлөвлөгөөний дагуу 1, 2 дугаар улиралд тус бүр нэг, жилийн эцэст нэг удаа дотоод хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэн тайланг гаргаад байна.
- Байгууллагын 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг захирлын 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан. Уг төлөвлөгөөний дагуу А/10 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулагдаж 02 дугаар сарын 08-ний өдөр хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчдийг сонгон шалгаруулах нээлттэй цахим тендер шалгаруулалтыг зарласан(дэлгэрэнгүйг тайлангийн дараагийн хэсэгт)
- Байгууллагын сургалтын төлөвлөгөөг баталсан, мөн хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр зэрэг төлөвлөлтийн баримт бичгүүдийн хэрэгжилт зохих ёсоор хийгдэж байна(дэлгэрэнгүйг: дараагийн хэсгүүдэд).


2.3. Худалдан авах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн:

“Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ-ын захирлын 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/03 дугаар тушаалаар 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлагдаж, А/10 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо 2023 онд хүнсний бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх гүйцэтгэгчдийг сонгох худалдан авах ажиллагааг зохион байгууллаа.

02 дугаар сарын 08-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр 19 багц бүхий нэг нээлттэй тендер шалгаруулалтыг нийтэд зарлан зохион байгуулсан.

Амжилтгүй болсон багцууд дээр дахин 06 дугаар сарын 05, 08 дугаар сарын 11, 09 дүгээр сарын 01-ний өдрүүдэд тус тус нийт 4 удаа тендер шалгаруулалтыг зохион төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулж дуусгасан. Шалгарсан аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан амжилттай хэрэгжиж байна.

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу хуульд зааснаар 20 сая төгрөгөөс доош үнийн дүн бүхий 8 нэр төрөл дээр шууд худалдан авах гэрээг 01 сарын 02-ноос 10-ны өдрийн дотор байгуулан, худалдан авалт хийгдэж байна.



- Тайлант хугацаанд гэрээний дагуу харилцагч нийт 20 аж ахуйн нэгжээс 27 төрлийн 110 орчим нэрийн хүнсний бүтээгдэхүүнийг татан авалт хийж ажиллалаа.

Үүнд:

- Грийн ХХК /ТЭСО корпораци/
- Боса Импекс ХХК
- Хулагу холдинг ХХК
- Улаанбаатар гурил ХХК
- Томбат ХХК /Галх чихэр ХК/
- Коубой мийт ХХК

- Эрдэнэ Энх Трейд ХХК
- Арвин мөнх дэлгэрэх ХХК
- Шувуутайн гол ХХК
- Ганга түшээ ХХК
- Далай хүч ХХК
- Милл хаус ХХК
- Сүпер ирээдүй ХХК
- СэТэБи ХХК
- Эдэн ХХК
- Фүүд сервис солюшн /Таван Богд групп/
- Мөх дээж ХХК
- Баттрейд си ХХК
- Нарт Уул ХХК
- Хөвсгөл их тайга

2.4.Үйл ажиллагааны зардлыг бууруулах, санхүүгийн сахилга батыг сайжруулах, өр авлагыг барагдуулах, эдийн засгийн үр өгөөж, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх талаар хийсэн ажлын талаар:

2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 1,882,780.0 төгрөгийн авлага, 36,396,988 төгрөгийн татварын өглөг байсныг бүрэн төлж барагдуулсан. Харин тайлант жилд 11.2 тэрбум төгрөгийн өглөг үүссэнээс жилийн эцсийн байдлаар 10.9 тэрбум төгрөгийн дансны өглөгийг 99.5 хувь төлж барагдуулсан бөгөөд 150.8 сая төгрөгийн татварын өглөгийн үлдэгдэлтэй байна. Уг өглөгийг 2024 оны эхний улиралд төлж барагдуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Тухайн онд 10.7 тэрбум төгрөгийн авлага бүртгэгдсэнээс 1.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Манай байгууллага жилийн төсөв, зорилтыг төлөвлөхдөө ямар нэгэн үр ашиггүй зардал тусгадаггүй бөгөөд үйл ажиллагаа явуулахад зайлшгүй гарах зардлуудыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар хянаж баталдаг.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд

- “Тэс Петролиум” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулснаар хүнсний түгээлтийн авто машинудын шатахууны зардлыг 5 хувь буюу 1,3 сая төгрөгийн хэмнэлт

- Манай байгууллагын хүнсний агуулах, оффисын барилга хуучирч муудсан тул урсгал засварыг жил бүр хийх шаардлагатай байдаг. 2023 онд засварын зардал 19 сая төгрөгөөр батлагдсан боловч гүйцэтгэгч аж ахуйн нэгжтэй гэрээ хийлгүйгээр зуны ажлын ачаалал багатай үед өөрийн ажилтнуудын хүчээр засварын ажлыг хийснээр 4.2 сая төгрөг хэмнэж ажилласан байна.

➤ Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Тус газар нь дээрх хууль, тогтоол шийдвэрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд дараах байдлаар ажилласан байна.

- Үүсгэн байгуулагдсан цагаасаа тэргүүн, дэд, орлогч дарга, зөвлөх гэх зэрэг албан тушаалгүй ажилладаг

- 2023 он гарснаас хойш тус байгууллагын захирал, ажилтнууд ямар нэгэн дотоод, гадаад томилолтод яваагүй

- Улс, нийслэл, орон нутаг, байгууллагын өөрийн зэрэг аливаа эх үүсвэрээр тухайн онд ямар нэгэн барилга, байгууламж баригдаагүй, төлөвлөгдөөгүй байна

- Хүнс ачиж буулгах, тээвэрлэх ажилтнуудад ажлын буюу нормын хувцас гутал

хэрэглэдэг. Бусад ямар нэгэн дүрэмт хувцас хэрэглэдэггүй. Хууль тогтоомжид заагаагүй ямар нэгэн урамшуулал, тэтгэмж, шагнал олгоогүй

- Орон тооны давхардал байхгүй. Бүх ажилтнууд өөр өөр чиг үүрэгтэйгээр ажилладаг

- Байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг огт хийгээгүй, санхүүжүүлээгүй байна

- Аливаа хэлбэрийн бэлэг дурсгалын зүйл огт худалдан аваагүй, захиалаагүй болно

- Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авч байгаагүй

- 2023 онд сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зохион байгуулаагүй. Дотоод албан томилолт төлөвлөөгүй, хийгдээгүй. Засгийн газраас цэцэрлэгийн насны хүүхдийг 100 хувь хамруулах зорилтын хүрээнд хичээлийн байр олноор нэмэгдсэнээр хүнс түгээх ажил ихэссэн тул шатахууны зардлыг хэмнэх боломжгүй байна

- Бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардал батлагдсан төсвийн хэмжээнд гарч байгаа.

- Мөн хууль, тогтоомж дахь бусад заалтуудыг чанд мөрдөж, тэвчиж болох зардлуудыг тэвчиж зөрчил гаргалгүйгээр ажилласан

2.5.Тайлант оны төсөв, төлөвлөгөөнд тусгагдаагүй шинээр санаачилж хийсэн бүтээлч ажил, чанар, үр дүн:

2.5.1. 2023 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр харилцагч нийт цэцэрлэгүүдийн хүнсний нярвуудад, тогооч нарт хүнсний бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, түгээх, хүүхдийн хүнсний онцлогийн талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлж, хөгжүүлэх, чадваржуулах практик сургалт, арга хэмжээг зохиох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгууллаа. Уг арга хэмжээг цэцэрлэгүүдийн төмс, хүнсний ногоо, нарийн ногоог нийлүүлэгч “Эрдэнэ энх трейд” ХХК-ийн Сэлэнгэ аймгийн Мандал сум, Хэрх багт байрлах тариалангийн талбай, Сонгино хайрхан дүүргийн 20-р хороонд байрлах Хүнсний ногооны агуулахын талбайд тус тус очиж зохион байгуулсан.

Орлцогчид эх орны хөрсөнд ургасан цэвэр байгалийн гаралтай төмс, хүнсний ногоо, зарим нарийн ногоог хэрэглэж байгаадаа талархахын зэрэгцээ, тариалалт, хадгалалт, хураалт, тээвэрлэлт хэрхэн хийгддэгийг газар дээр нь нүдээр үзэж, мэргэжлийн аграномич, хоол, шим зүй судлаачаар хичээл заалгаж, үр дүнтэй арга хэмжээ болсон гэж дүгнэсэн.

Сургалт, арга хэмжээнд 94 цэцэрлэг тус бүрээс 2 ажилтан, байгууллагын 18 ажилтан, нийт 202 хүн хамрагдсан байна.





“НАМРЫН НОГООН ӨДӨР-2023” АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Зорилго: Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад гэрээний дагуу хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгч “Эрдэнэ энх трейд” ХХК-ийн үйл ажиллагаа, тариалалт, хадгалалт, боловсруулалттай газар дээр нь очиж танилцах, зохих онолын болон практик мэдлэг олж авах, санал солилцох.

Оролцогч: Нийслэлийн Баянзүрх, Хан-Уул дүүргийн Сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд тус бүрээс хүнсний нярав-1, тогооч-1 буюу нийт 2 ажилтан хамрагдана.

Хэзээ: 2023.09.09-ний өдрийн 08:30-20:00 цагт

Хаана: Сэлэнгэ аймгийн Мандал сум, Хэрх баг, Тэмээтийн хонхор

Цуглах газар: Баянзүрх дүүргийн цэцэрлэгүүд: Жуковын хөшөөтэй талбайд
Хан-Уул дүүргийн цэцэрлэгүүд: “Мишээл Экспо” Худалдааны төвийн талбайд
цуглаад нэгдсэн автобусаар хөдөлнө.

Д/д	Үйл ажиллагаа	Хугацаа	Тайлбар, хариуцах хүн
1.	Тогооч, нярвуудын бүртгэл	08:30-08:35	Өсвөр үе хүнс, нярвууд
2.	Оролцогчид “Эрдэнэ энх трейд”-ийн ХХК-ийн Хүнсний агуулах руу хөдлөх	08:40-09:30	СХД-ийн 20-р хороо, Сонсголон
3.	“Өсвөр үе хүнс” ОНӨААТҮГ-ын захирал Г.Мөнхзул арга хэмжээг нээж, танилцуулга хийнэ	09:30-09:40	Төмс, хүнсний агуулахын байранд
4.	Оролцогчид “Эрдэнэ энх трейд”-ийн ХХК-ийн Хүнсний агуулах, хадгалалт, тээвэрлэлтэй танилцах	09:40-10:10	“Эрдэнэ энх трейд”-ийн ХХК-ийн Ерөнхий менежер Д.Туяа
5.	Өглөөний цай	10:10-10:40	Нийт оролцогчид
6.	Тариалангийн талбай руу хөдөлнө	10:40-13:40	Нийт оролцогчид
7.	Өдрийн хоол	13:40-14:40	Нийт оролцогчид
8.	Төмс, хүнсний ногооны тариалалт, хураалт, тээвэрлэлт, талбайтай танилцах	14:40-16:30	“Эрдэнэ энх трейд”-ийн ХХК-ийн захирал Б.Чинбаяр, ажилтнууд
9.	Хүнсний ногоог хоол, хүнсэнд хэрэглэх, хадгалах арга зүйн талаарх сургалт	16:30-17:00	“Эрдэнэ энх трейд”-ийн ХХК-ийн Хүнсний технологич
10.	Нийт оролцогчид дурсгалын зураг татуулах	17:00-17:20	Өсвөр үе хүнс
11.	Нийт оролцогчид Улаанбаатар хот руу хөдөлнө	17:20-20:20	Оролцогчдыг өглөө цугласан газарт нь хүргэнэ



2023.09.09. Сэлэнгэ аймаг, Мандал сум

2.5.2. Харилцагч цэцэрлэгүүдээс удаа дараа ирүүлсэн хүсэлтийн дагуу “Грийн групп” ХХК-д манай байгууллагаас санал хүргүүлсний дагуу 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр нийт 84 цэцэрлэгийн тогооч, нярвуудыг хамруулан цэцэрлэгүүдэд нийлүүлдэг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалт, хадгалалт, түгээлт, шинжилгээ баталгаажилт үйлдвэрлэлийн шатанд хэрхэн явагддаг байдалтай газар дээр нь танилцуулах арга хэмжээг зохион байгууллаа. Грийн групп ХХК нь гэрээний дагуу цэцэрлэгүүдийн хэрэглээний элсэн чихэр, цагаан будаа, 5 төрлийн бусад будаа, 4 нэр төрлийн гоймон зэрэг бүтээгдэхүүнийг ханган нийлүүлж ажилладаг бөгөөд уг арга хэмжээний үеэр тус компанийн хүнсний технологич, зохих мэргэжлийн хүмүүсээс тогооч, нярвуудад өөрийн бүтээгдэхүүний онцлог, давуу тал, шинж чанарын талаар олон талын ойлголт өгөх сургалтыг зохион байгуулсан нь үр дүнтэй болсныг арга хэмжээнд оролцогчид дүгнэж байлаа.

2.5.3. 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Баянзүрх дүүргийн “Жанжин клуб”-д болсон Баянзүрх дүүргийн нийт 54 цэцэрлэгүүдийн эрхлэгч, багш, арга зүйчдийн дунд зохион байгуулагдсан хичээлийн жилийн хаалтын арга хэмжээнд манай байгууллага хамтран оролцлоо. Ковид-19 цар тахлын улмаас бид цэцэрлэгийн эрхлэгч нартай биечлэн уулзаж, хамтын ажиллагааны талаар аливаа уулзалт, хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулаагүй байсан. Уг арга хэмжээн дээр бид цэцэрлэгийн удирдлагуудад хүнсний бүтээгдэхүүний худалдан авах ажиллагаа хэрхэн явагддаг, татан авалт, шинжилгээ, баталгаажилт, хадгалалт, хамгаалалт, түгээлтийн процесс хэрхэн өрнөдөг, үнийн бодлого яаж явагддаг, хүнсийг технологийн шатанд боловсруулах, хэрэглэхэд удирдлагын зүгээс юуг анхаарах, буцаалт, гомдол санал гарах тохиолдолд юуг анхаарах зэрэг олон чухал асуудлын талаар мэдээлэл өгч, хэлэлцүүлэг хийсэн нь шинээр томилогдсон олон эрхлэгч нарт мэдлэг, туршлага өгсөн, үр дүнтэй бүтээлч ажил, арга хэмжээ болсон.

2.5.4. Нийслэлийн нутгийн захиргааны болон нийслэлийн өмчит байгууллагуудад иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл

ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай НЗДТГ-ын даргын удирдамжийн дагуу ажлын хэсэг 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр манай байгууллага дээр ирж ажиллалаа. Уг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд НЗДТГ-ны холбогдох хэлтсийн дарга, албан тушаалтнууд, Нийслэлийн Архивын газрын мэргэжилтнүүд багтсан.



ГУРАВ. БУСАД ҮЗҮҮЛЭЛТ

3.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартын шаардлагыг мөрдөж хэрэгжүүлсэн ажлын үр дүн:

№	Төлөвлөгөөт ажил	Үр дүн
1	Хөдөлмөрийн аюулгүй байдлын давтан зааварчилгаа болох өдөр тутмын зааварчилгааг суурин нярав, жолооч, ачигч, үйлчлэгч, сахиул нарт танилцуулж ажилд гаргаж байх.	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны давтан зааварчилгаа болох өдөр тутмын зааварчилгааг касс, аж ахуйн нярав, суурин нярав, жолооч, ачигч, үйлчлэгч, сахиул нарт танилцуулж ажилд гаргаж байна. Байгууллагын ХАБЭА-н журмын хэрэгжилт, ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг хангуулан байнгын хяналт тавин ажиллаж байна.
2	Шинээр ажилд орсон ажилтанд хөдөлмөрийн аюулгүй байдлын урьдчилсан зааварчилгаа өгөх	2023 оны жилийн эцсийн байдлаар жолооч, ачигчийн ажилд шинээр орсон 11 ажилтанд Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, Ачих буулгах ажлын аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5079:2001 стандарт, 2021 оны 11-р сарын 01-ний өдөр батлагдсан “Ачигчийн гараар ачаа өргөх, зөөх, шилжүүлэх үеийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны

		зааварчилгаа”, “Жолоочийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г тус тус танилцуулсан. Урьдчилсан зааварчилгааны дэвтэрт гарын үсэг зуруулж баталгаажууллаа. Шинээр ажилд орсон ажилтанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар анхан шатны мэдлэг, мэдээллийг мөн өгсөн болно.
3	Эрүүл ахуйн шаардлага хангасан хөдөлмөр хамгааллын хувцас, гутал, нуруу хамгаалах бүс, бээлий, амны хаалтаар хангах	<p>Ажилтан албан хаагчдын хөдөлмөрлөх хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн хувцас солих, түр амрах, хооллох зориулалтаар хуучин оффис байсан 2 өрөөг тохижуулж ахуйн байртай болсон.</p> <p>Ажлын тусгай хувцсыг 2023 жилийн эцсийн байдлаар хуваарийн дагуу нийт жолооч, ачигч, үйлчлэгч нарт давхардсан тоогоор 128 ширхэг 7,649,400 төгрөгний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан махны, ногооны, өдөр тутмын гэсэн 3 ээлжийн ажлын хувцсыг захиалгаар хийлгүүлж, ажилтны хэвийн ажиллах нөхцөлийг хангаж ажилласан.</p> <p>Хувийн хамгаалах хэрэгсэл болох амны хаалт, бээлийгээр өдөр тутам хангаж хэвшсэн.</p> <p>Нурууны хамгаалах бүс PW-80 загварын 11 хамгаалах бүсийг шинээр худалдан авч шинээр ажилд орсон ажилтан болон хамгаалалтын бүс нь муудсан ажилтнуудад олгосон.</p>
4.	Хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтыг зохион байгуулах	<p>1.“Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, стандартууд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм”</p> <p>2.“Нэг бүрийн хамгаалах хэрэгслүүд, анхан шатны тусламж” сэдвээр давтан зааварчилгаа авдаг жолооч, ачигч, агуулахын нярав, үйлчлэгч нарт сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Хүний нөөц, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтан Ш.Сэргэлэн нь хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны мэргэшүүлэх 21 хоногийн сургалтад суусан бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд шалгалт өгч тэнцэн 20231452 дугаартай сертификатад авсан.</p>
5	Хүнстэй харьцдаг ажилчдад эрүүл мэндийн урьдчилан	БЗД-ийн Эрүүл мэндийн төвтэй хамтын гэрээ байгуулсан гэрээний дагуу урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг 2023 оны 03 дугаар сарын 21, 9 сарын 22-ны өдөр тус тус зохион байгуулж, одоо ажиллаж байгаа

	<p>сэргийлэх үзлэг шинжилгээг хийлгэх</p>	<p>нийт ажилтан, албан хаагчдыг хамруулж хяналт тавьж, бүртгэл хөтлөн ажиллалаа. Шинжилгээгээр эрүүл мэндийн үзлэгт тэнцээгүй ажилтан байхгүй.</p> <p>Эрт илрүүлэг эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамрагдаагүй байсан 17 ажилтныг 2023 оны 11 дүгээр сард тус байгууллагаас зохион байгуулж 1 өдрийн цалинтай чөлөө олгож “Рехамед” эмнэлэгт холбогдох эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулсан.</p>
<p>6.</p>	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж, хүнсний бүтээгдэхүүн нийлүүлдэг сургууль, цэцэрлэгт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтыг сайжруулах</p>	<p>“Харилцагч цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, хүнсний агуулахад зөвлөх үйлчилгээ”-ний ажлын удирдамжийг, ажлын хэсгийн бүрэлдэхүүний хамтаар байгууллагын захирал баталсан. Бүрэлдэхүүнд менежер Б.Зоригоо эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан Г.Энхбуд, Б.Болортуяа, хүний нөөц, ХАБ хариуцсан ажилтан Ш.Сэргэлэн нарын бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж 8-р сар буюу хичээлийн шинэ жил эхэлснээс хойш үйл ажиллагаагаа эхлүүлсэн 11 цэцэрлэг дээр очиж зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж ажилласан байна.</p> <p>Харилцагч цэцэрлэгүүдийн тогооч нарт зөвлөн туслах үйлчилгээгээр ХАБ-ын зааварчилгаа өгч цэцэрлэгүүдийн гал тогоонд ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хэрэгжилтийг хангаж ажиллаа.</p>
<p>7</p>	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартын шаардлагыг мөрдөж хэрэгжүүлэх чиглэлээр шинээр ажил санаачилж хэрэгжүүлэх</p>	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартын шаардлагыг мөрдөж хэрэгжүүлэх чиглэлээр шинээр аюулыг мэдээлэх журмыг баталж, аюулыг мэдээлэх хуудсыг нэвтрүүлсэн нь үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, ажлын байран дахь эрсдлийг бууруулах ажлыг шинээр санаачилж хэрэгжүүллээ. Аюулыг мэдээлэх хуудсыг хүлээн авах хайрцагийг байршуулсан.</p>

- Хүний нөөц, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтан Ш.Сэргэлэн нь 5, 6 дугаар сард хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны мэргэшүүлэх 21 хоногийн сургалтад суусан бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд шалгалт өгч тэнцэн 20231452 дугаартай сертификатыг авсан. Доор үзүүлэв:



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

СЕРТИФИКАТ

№ 20231452

Шаандар

овогтой

Сэргэлэн

нь

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны сургалт”-нд суралцаж төгссөн тул
СЕРТИФИКАТ олгов.

Сургалтын байгууллагын нэр: **АМЖИЛТ БОЛОМЖ ГАРЦ ТББ**
сургалтын төв

Суралцан төгссөн огноо: **2023/06/06**



ХӨДӨЛМӨР АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ

М.ДАВААБАТ

3081486 1116129007

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

Олгосон огноо

20.23. он . 06. сар . 13. өдөр



Овог нэр: **Шаандар Сэргэлэн**
 Регистрын дугаар: **ЧВ76062518**
 Үнэлгээ: **Онол 86%**
Ур чадвар 80%



Хичээлийн сэдэв	Хичээлийн цаг			
	нийт	лекц	семинар	дадлага
1. Удиртгал хичээл	2	2		
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж	8	5	3	
3. Хөдөлмөрийн аюулгүй байдал	18	8	4	6
4. Хөдөлмөрийн эрүүл ахуй	18	10	6	4
5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зааварчилгаа	10	4	4	2
6. Эрсдэлийн менежмент	12	6	3	3
7. Хувийн хамгаалах хэрэгслийн хэрэглээ, тавигдах шаардлага	10	5	3	2
8. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх, мэдээлэх, дүн шинжилгээ хийх	10	6	3	1
9. Аюулыг илрүүлэх, мэдээлэх харилцаа	10	5	3	2
10. Гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдал, галын аюулгүй ажиллагаа	6	4	2	
11. Хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	10	6	4	
12. ХАБЭА-н менежментийн тогтолцоо	10	8	2	
13. НИЙТ	124	69	37	20
Дүн				

“АМЖИЛТ БОЛОМЖ ГАРЦ” ТББ

Сургалтын байгууллагын нэр



(гарын үсэг)

Ц.ОТГОНСҮРЭН

Дарга, захирлын нэр

3.2. Ажилчид, албан хаагчдын ур чадвар, мэргэшлийн түвшинг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хариуцлага сахилгыг өндөржүүлэх, ёс зүйг сахих чиглэлээр санаачилж хийсэн ажил, үр дүн:

Хөгжүүлэх, сургах чиглэлээр:

- Хүний нөөц, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтан Ш.Сэргэлэн нь Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны мэргэшүүлэх 21 хоногийн сургалтад 2023 оны 05 дугаар сард суралцсан бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд шалгалт өгч тэнцэн 20231452 дугаартай сертификатыг авсан. Байгууллагаас сургалтын төлбөрт 100,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
- Архив, бичиг хэргийн ажилтан Б.Эрдэнэчимэг нь Архивын Ерөнхий газраас 2023 оны 10 дугаар сарын 16-аас 2023 оны 11 дүгээр сарын 17-ны хооронд зохион байгуулжсан “Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтны мэргэжлийн сургалт”-д хамрагдсан тул суралцах хугацааны цалинтай чөлөөг олгож, сургалтын төлбөр 250,000 төгрөгийг байгууллагаас гаргасан. Б.Эрдэнэчимэгийг дээрх сургалтад суралцаж төгссөний дараа нэгээс доошгүй жил тус байгууллагад тухайн чиглэлээр ажиллахаар харилцан тохиролцсон.
- Тус байгууллагад ачигч ажилтай Д. Өлзийсайханыг жолоочийн С ангиллын сургалтад 2023 оны 12 дугаар сарын 01-ээс 2023 оны 12 дугаар сарын 15-ны хооронд суралцуулж, сургалтын төлбөр 300,000 төгрөгийг байгууллагаас төлсөн. Д.Өлзийсайханыг дээрх сургалтад суралцаж төгссөний дараа хоёроос доошгүй жил тус байгууллагад жолооч, ачигчаар ажиллуулахаар харилцан тохиролцсон.
- Архив, бичиг хэргийн ажилтан Б.Эрдэнэчимэг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгож, АЗ гэрчилгээ авах сургалтад 2023 оны 12 дугаар сарын 6-наас 8-ны өдрүүдэд суусан. Сургалтын төлбөр болох 80,000 төгрөгийг байгууллагаас төлсөн.

Нийгмийн асуудлыг шийдэх чиглэлээр:

- “Өсвөр үе хүнс” ОНӨААТҮГ-ын Ажилтан албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны 2023-2026 оны хөтөлбөрийг боловсруулж баталсан. Ажилтан албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хүрээнд 2023 онд ажилтан албан хаагчдын үндсэн цалингийн хэмжээг 20 хувиар нэмэгдүүлэхээр төлөвлөж, Нийслэлийн Өмчийн харилцааны газраар батлуулж, олгож эхэлсэн.
- Шинээр 1 өрөө байр худалдан авсан ажилтанд байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу нэг сая төгрөгийн мөнгөн тэтгэмжийг олгосон.
- Ар гэрийн гачигдал тохиолдож гэр бүлийн ойр дотны хүн нь нас барсан 5 ажилтанд нийт нэг сая долоон зуун мянган төгрөгийн нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг тус тус олгосон.
- Ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрыг хөгжүүлэх, дархлааг нэмэгдүүлэх зорилгоор спорт заалыг 7 хоног бүр 2 цагийн хугацаатай авахаар “Кайрос” ХХК-тай гэрээ байгуулсан бөгөөд 7 хоног бүр спорт зааланд спортоор хичээллэж цагийг зөв боловсон өнгөрүүлж байна.

- “Өсвөр үе хүнс” ОНӨААТҮГ-ын 2023 оны сургалтын төлөвлөгөөний дагуу “Стресс менежмент” сэдвээр Монголын Сэтгэцийн эрүүл мэндийн нийгэмлэгийн тэргүүн Н.Алтанзул, “Хүмүүс хоорондын харилцаа, харилцан хандлага” сэдвээр Franklin Covey сургалтын төвийн багш Б.Солонгоо нар нийт ажилтан албан хаагчдад хичээл заалаа.



“Стресс менежмент” сургалт 2023.03.24

- Архив, бичиг хэргийн ажилтан Р.Мөнхбаяр НЗДТГ-аас манай байгууллагын 2022 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлсэн үнэлгээний багийн гишүүдийн зөвлөмжийн дагуу албан хэрэг хөтлөлт, архивын хууль тогтоомжууд, Баримт бичгийн стандарт (MNS5140:2021)-ын талаарх сургалтыг ажилтан албан хаагчдын дунд зохион байгууллаа.
- Нэг ажилтан хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны мэргэшүүлэх 21 хоногийн сургалтад сууж ХНХЯ-наас олгодог сертификатыг авсан.

Сахилга, ёс зүй сахих чиглэлээр:

Тус байгууллагад одоогийн байдлаар нийт 30 /үүнээс 2 ажилтан түр ажлын байранд/ ажилтан, албан хаагч ажиллаж байна. Сул орон тоогоо олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарладаг бөгөөд зарын дагуу сул ажлын байранд ажилд орохоор ирж байгаа иргэнээс байгууллагын менежерийн хамт нэгбүрчлэн ярилцлага авдаг. Шинээр ажилд орж байгаа ажилтанд байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ болон албан тушаал /ажлын байрны тодорхойлолтыг танилцуулж байгууллагын үйл ажиллагаанд хориглосон, хязгаарласан зүйл заалтыг тодорхой тайлбарлан таниулж байна. Ажилтан албан хаагчдын сахилга хариуцлагыг өндөржүүлэх, ёс зүйг сахих чиглэлээр байгууллагын хурал болон бусад үйл ажиллагааны үеэр байнга сануулж байна. Мөн ажилтан албан хаагчдын ажилдаа ирсэн явсан цагийг бүртгэж хэвшсэн.

Монгол Улсын Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг 2023 онд шинээр баталсантай холбогдуулан байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороог 3 гишүүнтэйгээр байгууллагын захирлын 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/44 дүгээр тушаалаар байгуулсан. Дээрх хуульд нийцүүлэн байгууллагын “Ажилтан, албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг 2023 оны 10 дугаар сард шинэчлэн боловсруулж батлуулсан.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон ёс зүйн шинэ дүрмийг танилцуулах зорилгоор байгууллагын нийт ажилтан, албан хаагчдад сургалт зохион байгуулсан.

2023 онд ажлын цагаар согтууруулах ундаа хэрэглэсэн, ажил тасалсан ёс зүйн зөрчил гаргасан жолооч Т.Гансүхэд 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Сахилгын шийтгэл ногдуулах тухай” Б/07, ачигч Э.Намсрайд 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Сахилгын шийтгэл ногдуулах тухай” Б/09, жолооч Д.Ганбаатарт мөн өдрийн сахилгын шийтгэл ногдуулах тухай Б/10, түгээлтийн нярав Б. Бат-Эрдэнэд 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн “Сахилгын шийтгэл ногдуулах тухай” Б/54 дугаар тушаалаар тус тус сануулах, үндсэн цалинг тодорхой хугацаагаар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан

Ачигч С.Пүрэвдалай ажлын байраа орхиж явсан тул 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн Б/11, ачигч Т.Цэрэндорж нэр бүхий ажилтнуудын биед халдаж эрүүл мэнд, гоо сайханд гэмтэл учруулсан тул 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн Б/27, ачигч П.Шинэбаяр худал хэлж шалтгаангүйгээр дараалан 4 өдөр ажил тасалсан тул 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн Б/28, ачигч Н.Ганхуяг, Г.Бямбадорж, Г.Чинзориг нар согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ 4-7 хоног дараалан ажил тасалсан тул 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Б/54, Б/55, Б/56 дугаар тушаалаар тус тус ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулсан.

Манай байгууллага дээр ачигч, жолооч нар ажлын цагаар согтууруулах ундаа хэрэглэх, хэрэглэсэн үедээ ажлын байранд ирэх, ажил таслах, бусдыг хэл амаар доромжлох, танхайрах зэрэг нийтлэг зөрчлүүд гарсан.

3.3. Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлт, холбогдох журмын хэрэгжилт

Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн "UB ERP" дотоод удирдлагын системд тус 2023 онд 16 өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэсэн байна. Үүнд: Цалингийн тодорхойлолт олгох 15 өргөдөл, Жолооны С ангиллын сургалтад хамруулж өгөхийг хүссэн 1 өргөдөл ирсэн ба хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан. Иргэд, олон нийт, харилцагчдаас үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол, хүсэлт ирээгүй байна. Бүх өргөдөл, хүсэлтүүд зөвхөн дотоодоос ирсэн өргөдлийг хүлээн авч, холбогдох албан тушаалтанд танилцуулж хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэн ажиллаж байна. Тус байгууллагад ирсэн өргөдлүүдийг зохих журмын дагуу egr.ulaanbaatar.mn-д бүртгэн оруулж шийдвэрлэлтийг захиралд эргэн танилцуулж ажилласан.

3.4. Захирамжлалын болон дотоодод үүсэж хөтлөгдсөн баримт бичгийн боловсруулалт, эрх зүйн чадамжтай байдал.

2022 оны байдлаар захирамжлалын болон дотоодод үүсэж хөтлөгдсөн Байнга хадгалах 22 баримт, 70 жил хадгалах 3 баримт, Түр хадгалах 95 баримт нийт 120 баримтыг 2023 оны 1-р улиралд багтаан бүрэн бүрдэлтэйгээр хүлээн авч бүртгэлжүүлэн ажилласан байна.

Манай байгууллагын хувьд захирамжлалын баримт бичиг нь захирлын тушаал байдаг.

2023 он захирлын А тушаал 55, Б тушаал 64, нийт 119 тушаал гарсан байна.

2023 оны 1-р улиралд 2022 онд үүссэн захирамжлалын болон дотоодод үүсч хөтлөгдөсөн Байнга хадгалах 22 баримт, 70 жил хадгалах 3 баримт, Түр хадгалах 95 баримт нийт 120 баримтыг бүрэн бүрдэлтэйгээр хүлээн авч бүртгэлжүүлэн ажилласан байна. Харин 2023 оны баримтыг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 7.2.5, 7.2.6-д заасан шаардлагын дагуу ангилан төрөлжүүлж, хуудас бүрийг дугаарлан, дотоод товьёо, баталгааны хуудас үйлдэн, үдэж хавтаслахад бэлтгэж, батлагдсан хуваарийн дагуу жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан архивт баримт шилжүүлсэн акт (хавсралт 5) үйлдэж, архивт шилжүүлнэ гэж заасны дагуу 2024 оны 01 дүгээр улиралд багтаан бүртгэлжүүлэн ажиллах ёстой болно.

3.5. Мэдээллийн технологийн ололтыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах, үйлчилгээг шуурхай болгох зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй ажил, үр дүн:


Байгууллагын албан ёсны цахим хуудас болох childfood.ub.gov.mn вебсайт, “Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ-ын албан ёсны хуудас” – нэртэй фэйсбүүк хуудсаар дамжуулан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээ, тайлан, төлөвлөгөө, дүрэм, журам зэрэг 84 төрлийн мэдээ, мэдээллийг цаг тухай бүрт нь иргэд, харилцагч, олон нийтэд түгээж ажиллаж байна.

Манай байгууллага дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд үндсэн 2 үйл ажиллагааг явуулдаг.


Үүнтэй холбогдуулан:

1-рт: Харилцагч цэцэрлэг, сургуулиудад ханган нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүний захиалгыг байгууллагын цахим хуудас дахь дэд системээр дамжуулан онлайнгаар явуулж байна.


2-рт: Худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем буюу www.tender.gov.mn хуудсаар цахимаар, шуурхай зарлан явуулж, нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдэд хүндрэл, чирэгдэлгүйгээр цахим хэлбэрээр явуулж хэвшсэн байна. Мөн “Гайхам” ХХК-тай гэрээ байгуулсны үндсэн дээр хүнсний түгээлтийн 5 авто машинд GPS хяналтын төхөөрөмж болон түлш хянах төхөөрөмжийг суулгаснаар авто машинууд түгээлтийн чиглэл, маршрут, цагийн хуваарийн дагуу явж байгаа эсэх, санхүүгээс өгсөн түлшний талоныг зориулалтын дагуу зарцуулсан эсэх, түлшийг бүрэн ашиглаж эсэх зэрэг олон төрлийн хяналтыг тавин ажиллаж байна. Хяналтыг <https://www.gaikham.com/> цахим хуудас дахь өөрийн эрхээр нэвтрэн хэрэгжүүлж байна. Мөн нийслэлийн дотоод удирдлагын UB ERP цахим систем дэх дэд системүүдийг өөрийн үйл ажиллагаанд хамаарах хүрээнд бүрэн ашиглаж хэвшээд байна. Албан бичиг хүлээн авах, илгээх, өргөдөл гомдол авах, цаг бүртгэл хянах, хүний нөөцийн мэдээлээ хөтлөх, утасны жагсаалт ашиглах, баримт бичиг боловсруулах, хурал уулзалт төлөвлөх, зохион байгуулах, архив, хяналт шинжилгээ болон тайлан мэдээ гаргах гэх зэрэг бүх үйл ажиллагаа тус системийн тусламжтайгаар хэрэгжүүлж байна.



Байгууллагын цахим хуудас.



Байгууллагын фэйсбүүк хуудас



Худалдан авах ажиллагааг цахим системээр зохион байгуулж байна.

3.6.Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн байдал:

Маягт Б-ИБ-2, Байгууллага

ИРСЭН БИЧИГЭЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ
Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ
/2023.01.02-2023.12.28/

2024 оны 01 дугаар сарын 05 12:25

Д/д	Хэлтсийн нэр	Энэ хугацаанд ирсэн бичгийн тоо(A=A1+A2+A3)		Бүртгэгдсэн байдал				Хуваарилалт		Шийдвэрлэлтийн байдал							Хяалтын байдал					Улаанбаатар хот		
		A	A1	A2	A3	A4	A5	B	B1	B2	B3	B4	B5	B6	B7	C	C1	C2	C3	C4	C5	D	AT	DC1
		Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр	Байгууллагаар бүртгэгдсэн бичгийн тоо	Системээр бүртгэгдсэн бичгийн тоо	Хуваарилалдсан бичгийн тоо	Хуваарилалтаар бүртгэгдсэн бичгийн тоо	Үүнээс хариутай бичгийн тоо B=B1+B2+B4	Хугацаандаа шийдвэрлэсэн	Шийдвэрлэсэн	Шийдвэрлэлгүй	Судалж байгаа	Хугацаа дөхсөн	Хугацаа сунгуулсан	Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь	Үүнээс хариутай бичгийн тоо C=C1+C2+C4	Хугацаандаа хаасан	Хяалсан	Хяалалгүй	Судалж байгаа	Хариутай бичгийн хяалтын хувь	Нийт ирсэн бичгийн шийдвэрлэлтийн хувь	Шийдвэрлэлтийн дундаж	Албан бичгийн индекс	
1	2	160	0	14	146	160	0	46	46	0	0	0	0	0	100.00	114	114	0	0	0	100.00	100.00	3.82	
	Нийт	160	0	14	146	160	0	46	46	0	0	0	0	0	100.00	114	114	0	0	0	100.00	100.00	3.82	

Албан бичгийн индекс

Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ	0.4511
------------------------	--------

МЭДЭЭ ХЯНАСАН:
ЗАХИРАЛ

Г.МӨНХЗУЛ

МЭДЭЭ ГАРГАСАН:
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН

Б.ЭРДЭНЭЧИМЭГ

3.7. Байгууллагын үйл ажиллагаанд дотоод удирдлагын программ нэвтрүүлсэн байдал, үр дүн:

Нийслэлийн дотоод удирдлагын UB ERP цахим систем дэх дэд системүүдийг өөрийн үйл ажиллагаанд хамаарах хүрээнд бүрэн ашиглаж хэвшээд байна. Ирсэн, явсан албан бичиг хүлээн авах, илгээх, өргөдөл гомдол авах, цаг бүртгэл хянах, хүний нөөцийн мэдээлэл хөтлөх, утасны жагсаалт ашиглах, баримт бичиг боловсруулах, хурал уулзалт төлөвлөх, зохион байгуулах, архив, хяналт шинжилгээ болон тайлан мэдээ гаргах, бусад байгууллага, албан хаагчидтай мэдээлэл солилцох, цаг үеийн мэдээлэл, чиг үүргийг үндсэн хуудаснаас хүлээн авах гэх зэрэг бүх үйл ажиллагааг тус системийн тусламжтайгаар хэрэгжүүлж байна

3.8. Байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн:

Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагын <http://childfood.ub.gov.mn/> цахим хуудсанд нээлттэй байршуулах 98 шалгуур үзүүлэлтээс байгууллагын үйл ажиллагааны онцлогт хамаарах 68 төрлийн нээлттэй мэдээллийг байршуулж, тайланг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст цахимаар хүргүүлсэн.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Нийслэлийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийг хөгжүүлэх 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх, байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэд, хэрэглэгчдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг нээлттэй ил тод байлгах зорилгоор долоо хоног бүрийн Баасан гарагт “Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажилласан тайлан”-г Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газраас Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7-д заасны дагуу 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт, шууд гэрээ, байгууллага албан хаагчийн нөөц боломжид хийсэн холбогдох хууль тогтоомжид нууц ангилалд хамаарахаас бусад өөрт хамаарах судалгаа, мэдээллийг судалгааны нэгдсэн систем (sudalгаа.gov.mn)-д байршуулсан.

3.9. Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангасан байдал буюу шилэн дансны хөтлөлтийн байдал, үр дүн:

Байгууллагын цахим хуудас болон шилэн дансны хуудсанд жилийн байдлаар 145 мэдээлэл оруулах ёстойгоос одоогоор 140 мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулаад байна. Харин 5 мэдээллийг он дууссаны дараа буюу 01 сарын 15-ны өдрийн дотор оруулах хуулийн хугацаатай байна.

3.10. 2023 он гарснаас хойш болсон Нийслэлийн удирдах ажилтны Шуурхай зөвлөгөөний бүх хуралдаанд байгууллагын захирал Г.Мөнхзул оролцлоо. Шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг долоо хоног тутамд www.ulaanbaatar.mn цахим хуудсанд өөрийн эрхээр нэвтрэн тайлагнаж байна.



Удирдах ажилтны шуурхай хуралдаан

3.11. 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр болсон “ХҮҮХДИЙН ХООЛ ҮНДЭСНИЙ” Чуулганд оролцлоо.

Монгол Улс Алсын хараа- 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтээ “Эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, эх оронч хөрвөх чадвартай, оюунлаг бүтээлч иргэнтэй улс болж хөгжинө гэсэн зорилго тавьсан.

Боловсролын сургалтын байгууллагад 1.2 сая орчим хүүхэд суралцаж байна. Тэднийг эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох эрхийг хамгаалахад суурь асуудал болсон эрүүл мэнд, хоол шим тэжээлийн асуудлыг “Хүүхдийн хоол үндэсний чуулган”-аар хэлэлцлээ. Дэлхий нийтийн болон, манай улсын бодлогод тусгалаа олсон эдгээр зорилтыг хангахад оролцогч талуудын хамтын ажиллагаа чухал юм. Тиймээс боловсрол, эрүүл мэнд, хоол тэжээлийн талаар хэлэлцэж, хамтын шийдвэр гаргахаар “Хүүхдийн хоол” үндэсний чуулганыг зохион байгуулсан.

Чуулганд ЭМЯ, БШУЯ, ХХААХҮЯ, сургууль цэцэрлэгийн удирдлага, “Өсвөр үе хүнс” ОНӨААТҮГ, “Асгат” ОНӨААТҮГ, Багачууд хүнс ОНӨААТҮГ, Хүнс хангамж ОНӨААТҮГ-ын байгууллагуудын удирдлага, эрүүл ахуйч нар нар болон хот хөдөөгийн 1500 орчим төлөөлөгч оролцлоо.

Уг чуулганаар

- ЕБС, цэцэрлэгийн хүүхдийн үдийн хоолны чанар, хүртээмж
- Үдийн хоол хүүхдийн эрүүл мэндэд нөлөөлөх нь
- Үдийн хоолны зардлыг аав ээж, асран хамгаалагчтай хуваалцах боломж
- Дунд ахлах ангийн сурагчдыг үдийн хоолонд хамруулах боломж
- Эрүүл эко бүтээгдэхүүнийг үдийн хоолны цэсэнд багтаах
- Үдийн хоол сурлагын амжилтад нөлөөлөх нь гэх мэт олон чухал сэдвээр зөвлөлдсөн.



2023.06.06. Хүүхдийн хоол Үндэсний чуулган

3.12. 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр болсон “ХҮҮХДИЙН ХООЛ” Хэлэлцүүлэгт оролцлоо.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд хүүхдийн хоол хүнсний чанар, хүртээмжийг сайжруулах, хоол хүнсний үйлчилгээгээр дамжуулан нийгмийн олон талт асуудлыг шийдвэрлэх, ороцоог хангах зорилгоор Боловсрол шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, ХХААХҮ сайдын хамтарсан А/50, А/57, А/45 дугаарын тушаалын дагуу 2023 оны 04 сарын 10 нд “ХҮҮХДИЙН ХООЛ” СЭДЭВТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА. Хэлэлцүүлэгт нийслэл, дүүргийн ЗДТГ, дүүргүүдийн Боловсролын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар болон сургууль, цэцэрлэгийн удирдлага, Асгат ОНӨААТҮГ, Өсвөр үе ОНӨААТҮГ, Багачууд ОНӨААТҮГ, Хүнс хангамж ОНӨААТҮГ-ын байгууллагуудын удирдлага болон эрүүл ахуйч нар оролцлоо.

Уг хэлэлцүүлгээр:

1. Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний шим тэжээллэг байдал, хангамж, хүртээмж, чанар, аюулгүй байдлыг сайжруулахад тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам;
2. Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний хэрэглээнд орон нутагт үйлдвэрлэсэн хүнсний түүхий эд бүтээгдэхүүний ашиглалтыг нэмэгдүүлэх, нутгийн онцлогтой уламжлалт хоол хүнсний нэр төрлийг баяжуулан ахуй, хэрэглээний онцлогтой уялдуулан хэрэглэх боломж;
3. Хоол үйлдвэрлэлийн салбарт ажиллаж буй хүний нөөцийн хүрэлцээ, мэргэжлийн ур чадвар, цалин хөлсний хангамж, нийгмийн баталгаа;
4. Тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд сургууль, цэцэрлэгийн хоолны үйлчилгээний өнөөгийн нөхцөл, оролцогч талуудын чиг үүрэг, ажлын уялдааг сайжруулах боломж, шийдэл;
5. Төр, хувийн хэвшлийн үр дүнтэй хамтын ажиллагааны шийдэл;
6. Хүүхдийн хоолны санхүүжилтийн олон талт хэлбэр боломж шийдэл;
7. Сургуулийн хоол үйлдвэрлэлийн газрын үр ашигтай зохион байгуулалтын хэлбэр, шийдэл боломж сэдвүүдээр хэлэлцэж, саналыг чиглэл бүрээр нэгтгэж байна



2023.04.10 “ХҮҮХДИЙН ХООЛ” Хэлэлцүүлэг

3.13. Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 08 ны өдрийн 224 дүгээр тогтоолоор баталсан “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт”-ыг хэрэгжүүлэх үүднээс 2023 оны 01 сарын 03-ны өдөр Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ, Асгат

ОНӨААТҮГ, Багачууд хүнс ОНӨААТҮГ, Хүнс хангамж төв ОНӨААТҮГ-ын Захирлууд болон эрүүл ахуйч нар нийслэл дэх махны зарим үйлдвэрүүдтэй танилцаж судалгаа хийлээ



2023.01.03. Мах Импекс ХК-ийн байр


3.14. 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль, “Үдийн хоол” хөтөлбөрийн хэрэгжилт, хүнсний хангамжид үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөн туслах ажлын удирдамжийн дагуу БШУЯ-ны хоол үйлдвэрлэлийн хэлтэс, Боловсролын Ерөнхий газар, ХХААХҮЯ, НБГ зэрэг байгууллагуудын хамтарсан бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийн баг ирж хууль тогтоомжийн хэрэгжилт, үйл ажиллагаатай танилцах ажлыг хийв.



2023.04.20 Ажлын хэсгийн шалгалт

3.15.Тус байгууллагаас UCS 1104В “Төрийн байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага” стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын хашаанд ургадаг 6 улиас модны мөчрийг холбогдох стандартын дагуу тайрсан. Улиас модыг тайрснаар модны цаашдын ургалтад сайн байдаг бөгөөд 6-р сард улиасны унгарил гарахгүй, байгууллагын гадна орчны өнгө үзэмжид эерэг нөлөө үзүүлдэг давуу талтай.





4.16. Байгууллагын харьяа нэгжүүдийн үндсэн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан тухай мэдээлэл.

Байгууллагын захирал үйлдвэрийн газрын дотоод хяналт шалгалт зохион байгуулах 2023 оны ажлын төлөвлөгөөг баталсан. Уг төлөвлөгөөний дагуу 1, 2 дугаар улирлын хяналт шалгалтыг 03 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 3 хоног, 05 дугаар сарын Дотоод хяналт шалгалтын комисс буюу менежер Б.Зоригоо, ерөнхий нягтлан бодогч Ш.Отгонжаргал, хүний нөөц, ХАБ хариуцсан ажилтан Ш.Сэргэлэн нарын бүрэлдэхүүнтэйгээр доорх 8 чиглэлээр хийж гүйцэтгэсэн. Хийж гүйцэтгэсэн ажлын талаар Дотоод хяналт, шалгалтын илтгэх хуудсыг захиралд танилцуулсан болно. Үүнд:

- Хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдал
- Корона вируст халдвараас урьдчилэн сэргийлэх бэлтгэл
- Бүтээгдэхүүн татан авалт, түгээлтийн явц байдал

- Ажлын байр, агуулах, түгээлтийн автомашинуудын ариун цэвэр, эрүүл ахуй, халдвар хамгаалал, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн байдал
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн тухай хууль, дотоод журмын хэрэгжилт
- Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалал, санхүүгийн бүртгэлийн үйл ажиллагаа
- Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгч болон бусад аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан гэрээний хэрэгжилт, үр дүн
- Дээд газар, албан тушаалтнаас ирүүлсэн тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих гэсэн чиглэлүүдээр дотоодын хяналт шалгалтыг хийж дүгнэх хурлыг хийж гүйцэтгэлээ.

ТАНИЛЦСАН:

“ӨСВӨР ҮЕ ХҮНС” ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ



Г.МӨНХЗУЛ

ТАЙЛАНГ НЭГТЭЭН ГАРГАСАН

“ӨСВӨР ҮЕ ХҮНС” ОНӨААТҮГ-ЫН
МЕНЕЖЕР

Б.ЗОРИГОО